

Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоох нь: Асуудал ба шийдэл

МУИС-Хууль зүйн сургууль

Алтансүхийн Итгэлтөгс

Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоох нь: Асуудал ба шийдэл

1. Асуудлыг дэвшүүлэхүй:

“Шударга ёс бол үнэнч шударгаар амьдрах, хэнийг ч үл гомдоох, өөрсдийн үйл ажиллагааны үр шимийн хүртэх явдал мөн” Грекийн философич Улпиан хэлсэн үг санаанд орно. Шударга ёсны ойлголт, тодорхойлолт үүгээр зогсохгүй. Энэ нь магадгүй хүн мөс чанартай, сүнслэг оршихуйнхаа хувьд шударга ёсонд тэмүүлсээр түүнийг хайсаар л байдагтай холбоотой байж болох юм. Шударга ёсыг хайж хүн төрөлхтөн төр, хууль, шүүхийг бий болгосон. Гэвч шударга зүйл гэдэг хүн төрөлхтөний түүхэнд харьцангуйгаас харьцангуй ойлголт байсаар ирсэн. Чадахынхаа хэрээр хийж хэрэгцээнийхээ хэрээр авахыг нэгэн үе туйлын шударга гэсэн философи ноёлж байсан бол орчин үед тэрэн шиг шударга бус зүйл байхгүй гэж үздэг нь шударга ёс харьцангуй болохын нэг жишээ. Хэдий тийм боловч авлига авахгүй байх нь шударга нийгмийн цогцлоох нэгэн томоохон алхам гэдэг нь мэдээж харьцангуй байх боломжгүй юм. Шударга ёсны зарчим нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зарчим гэдгээр хязгаарлагдахгүй нийгмийн бүхий л харилцаанд хамаарах өргөн ойлголт юм. Тиймээс энэхүү илтгэлдээ төрийн албан хаагчдийн авлигатай холбогдох асуудлийг ярихаасаа илүү оюутан бидний амьдралд байдаг шударга бус асуудлаас сэдэвлэн авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоох суурь зорилтыг дэвшүүлэхийг зорилоо.

Монтюсьегийн “Сайн хууль тогтоогч хүнийг шийтгэхээсээ илүүтэйгээр урьдчилан сэргийлэхэд анхаардаг. Тэрээр шийтгэхээсээ илүүтэйгээр ёс суртахууныг нь дээшлүүлэхийг хичээдэг ” хэмээн хэлсэнчлэн нэгэнт авилга авдаг сэтгэхүй төлөвшсөн хойно нь биш тийнхүү гүн гүнзгий төлөвшихөөс өмнө шударга бус байдлыг үзэн ядах сэтгэлгээг нийгэмд тэр дундаа боловсон хүчин бэлтгэгдэн гардаг оюутны ширээнээс энэ бүхнийг эхлэх нь зөв хэмээн оюун ухаандаа тунгаана.

“Юу тарина, түүнийгээ хурааж авна” гэсэн агуу үг юутай үнэн. Бид нийгмийнхээ хөрсөнд авилга гэсэн хар тамхийг суулгавал нийгэм дэх хүн бүр

хордох болно. Харин соргог байгаа дээрээ түүнийг үндсээр нь тасдаж хаях нь төр, хувь хүн, хуулийн этгээд бүгдийн үүрэг.

Монголын ард түмэн бид:

-улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
-хүний эрх, эрх чөлөө, **шударга ёс**, үндэснийхээ эв нэгдлийг **эрхэмлэн дээдэлж**,

-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
-хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
-эх орондоо хүмүүнлэг,

иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна. хэмээн Үндсэн хуулийнхаа оршил хэсэгт нийгмийн зорилго болгосон нь тунхаглалын төдий зүйл бус харин бүхий л үйл ажиллагаа дээрх зорилгод хүрэхийг төлөө байх болно гэдгийг иргэн бүр ухамсарлах үүрэг бий болгож байгаа хэлбэр.

Монголын нийгэм буюу иргэд бид өөрсдөө, төрийн засаглалд ашиг сонирхлын зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй байх чадвартай, соёлтой болохыг хичээж, төр маань зөрчил гаргаж байгаа дарга, түшмэдүүдтэйгээ хариуцлага тооцоод эхэлбэл манай нийгэм энэ аймшгийн гамшигт хөгцнөөсөө яваандаа салж, нийгмийн дархлаагаа сайжруулах болно.¹ Үнэхээр хээл хахууль өгөгч, авагч, зуучлагч өөрсдийнх нь энэ бүх үйлдлээс болж бусад хүмүүсийн эрх ашиг зөрчигдөж хичээл зүтгэл цаг хугацаа үнэ цэнэгүй болдгийг ойлгож ухамсарлалгүй хувийн ашиг сонирхлоо дээгүүрт тавьж хувиа бодсон зан гаргадаг нь нийгэмд тогтсон үзэгдэл болж буй нь сэтгэл эмзэглүүлнэ. Аливаа том үйлдэл жижиг үйлдлээс эхэлдэг. Бүгд л адилхан үнэт цагаасаа үрэн оочерлож зогсож байгаа нэгнийгээ хүндлэлгүй урдуур нь дайрагч нэгнээс авахуулаад оюутан бидний эрх ашгаа хамгаалуулахаар сонгодог зарим нэг Оюутны зөвлөлийнхөн оюутны байранд оруулахдаа 100000 мянган төгрөгийн ханш тогтсон гэж жишим ч үгүй хариулж байгаа нь сэтгэл эмзэглүүлж, нийгмийн шударга ёсыг тогтоох залуу үеийнхний дунд хожмын авлигачид төрж байгаа юм биш биз гэсэн бодол нийгмийн

¹Шударга ёс сэтгүүл., Д.Жаргал. Ашиг сонирхол өгүүллэг

авилгалын эсрэг сэтгэлгээг төлөвшүүлэх нь тулгамдсан асуудал юм байна хэмээн сонгож авлаа.

2. Авлигад хандаж байгаа нийгмийн өнөөгийн байдал

Монгол Улсын Авлигын эсрэг хуульд² “авлига” гэдгийг албантушаалынэрхмэдлээхувийнашигхонжоолоходурвууланашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийнэтгээдээстэрхүүхуульбусдавуубайдлыголжавахүйлдэл, эсүйлдэхүйгээрлрэхаливааэрхзүйнзөрчил хэмээн тодорхойлсон бөгөөд Хуулийн 5-р зүйлийн “Олон нийтийн соён гэгээрүүлэх ажиллагаа” гэсэн хэсэгт авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад таниулах зэрэг асуудлыг тусгаж өгсөн нь авлигыг зогсоох нь иргэдийн оролцоотой шууд хамааралтай болохыг хуулиар хүлээн зөвшөөрсөн байна. Энэ нь авлига хэмээх хар үүл нийгмийг бүрхэхээс өмнө түүнээс урьдчилан сэргийлэх нь чухал болохыг харуулж байна.

Авилгалын эсрэг НҮБ-н конвенцийн 13-р зүйлд “Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, бүлэгт түшиглэсэн байгууллага зэрэг төрийн албанаас гаднах бүлгийн идэвхитэй оролцоог хөхиүлэн дэмжих бөгөөд авилгал оршин байгаа, түүний үүсэх шалтгаан, цар хүрээ, учруулж байгаа аюул заналын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн өөрийн бололцооны хүрээнд авна.” хэмээн заасан байна. Энэхүү оролцоог авлигын үл тэвчих уур амьсгал бий болгоход хувь нэмэр оруулахад чиглэсэн олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа, дунд болон их, дээд сургуулийн хөтөлбөр зэрэг олон нийтийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, олон нийт мэдээлэл авах боломжтой байх зэрэг арга хэмжээгээр бэхжүүлэхийг үүрэг болгосон байна.

²Авлигын эсрэг хууль, 2006

“Залуу улс төр судлаачдын төв”-өөс 2010 оны 1 сард улс төрийн зонхилогч намуудад шинээр элсэн орж буй залуучуудын санаа бодлыг тандах судалгаагаар

- Улс төрийн нам бол засгийн эрхийг гартаа авах зорилготой хүмүүсийн нэгдэл- 82,3%
- Улс төрийн нам бол хүмүүсийн зорилгодоо хүрэх хамгийн дөт зам-33,3%
- Өөрт нь ашигтай бол намын дээд албан тушаалтны хууль бус үйл ажиллагааг дэмжин оролцоход бэлэн-24%
- Улс төрийн хүрээнд тусалж дэмждэг хүмүүст чадлынхаа хэрээр тусална- 61,7%
- Намын дэргэдэх залуучуудын байгууллагыг тэргүүлэн ажиллахад намын хэн нэгэн эрх мэдэлтний дэмжлэг хэрэгтэй-76,4%
- Ямар нэг ажил хийхэд хэн нэгэн эрх мэдэлтэнтэй тохиролцох хэрэг заавал гарна-41,2%
- Нам доторх сонгуулийн үйл ажиллагаанд ялахын тулд бэлэг өгөх нь буруу зүйл биш-29,4%
- Манай намын дарга надад chaser маркийн автомашин, Land200 маркийн автомашин авах ажилдаа туслуулахыг хүсвэл би чадах чинээгээрээ тусална-55,9% тус тус зөвшөөрсөн байна.

Үүнээс харахад залуучуудын дунд авлигыг үл тэвчих үзэл сул байгааг харуулж байна.

Авилгал эхлээд хүний зүрх сэтгэл, оюун санаа, бодлоос эхэлдэг бөгөөд бодол нь үйлдэл болон хувирдаг. Тэрхүү үйлдэл нь давтагдахад зуршил болдог. Зуршил нь хүний зан төлөвт нөлөөлдөг. Тиймээс хүн өөрийгөө авлига гэдэг хөнөөлт зүйлээс зөв ухамсартай байснаар хамгаалж чадна. Авлигын хор нөлөөг ухамсарлаж, бусдын амьдралаа шударгаар босгох гэсэн хүсэл эрмэлзлэлийг нураадаг гэдгийг цаг ямагт санаж байх хэрэгтэй. Нигер улсын авлигатай эсрэг тэмцэгчид хувь хүн авлигаас өөрийгөө хамгаалж, ёс суртахуунтайгаар сайн сайхныг олж авах 6 аргыг санал болгосон байна.³ Авлигын тухай мэдлэг, шахалт

³Ochulor, Chinenye Leo., Analysis of Corruption from the Ethical and Moral Perspectives

дарамтыг зайлуулах арга, боловсрол, боломжийг ашиглах, хувийн сахилга батаа дээшлүүлэх уйгагүй оролдлого зэргээр авлигыг үл тэвчих үзэл суулгах нь улс орны авлигатай тэмцэх үйлсд хувь нэмэр оруулна гэж үзжээ. Хурдан баяжих хүсэл, материалист үзэл, хувиа хичээх хандлагаа нийгмийн нэгдмэл байдлыг дэмжих үзэл, бусдын эрхийг хүндэтгэх үзэл, амьдралыг хэмжих хандлагаа өөрчилснөөр авлигын тэмцэлд үр дүн өгнө гэж бодож байна. Хүн болгон өөр өөрийн дахин давтагдашгүй шинжтэй учраас бүх хүнийг нэг хэвэнд цутгах гэсэн биш харин аливаа хүн эрхээ эдлэхдээ бусдын эрхийг хүндэтгэж шударга байх гэсэн сэтгэлгээг цэвэрхэн цаас шиг байдаг хүүхэд наснаас эхлэн төлөвшүүлэх нь авлигагүй нийгмийн үрийг тарьж байгаа хэрэг болох юм.

-

Бидний ирээдүй мэдлэгтэй нь бус хэдэнт өгрөгийн хандив өгсөн нь гүнзгий рүүлсэн сургалттай ангид элсч ордгийг харж, багшийн төлбөртэй давтлагад суучихвал “А” дүнавч болдгийг мэдэрч, хүмүүжиж байна-⁴ өгүүллэгт сурагчид багаасаа авлигыг тэвчиж төлөвшиж байгааг нотолсон байна. Бангладеш улсад 3 эмэгтэй оюутан тутмын 1 нь амьдралын түвшин доогуур оюутнуудад олгодог засгийн газрын тэтгэлэг авахын тулд мөнгө төлөхөөс буцдаггүй байна.

Авлигаас жирийн ардир гэднэлэнхүйдээ хохирчүлддэг.

“Хэнгуай албантушаалаа ашиглан авлига авч сайхан амьдарч болоод байхад бияа хаараа болдоггүй юм” гэсэн эзэн биегүй атааж өтөө газар авч, энэ нь эргээд нийгмийн шударга ёсыг алдагдуулж, эмх замбараагүй байдлыг бий болгоно. Ингээд л нийгмийг хамарсан ажилгүй-дэл, архидалт, хуульбуснаймаа, танилталын сүлжээ, эдийн засгийн луйвар... тэсч тэвчихийн аргагүй муумуухайнүүд хаалга өөрөө аяндаан ээгдэнэ. Биз-нес мэнүүд авлигад зарцуулсан мөнгөө бараа, бүтээг-дэхүүний хээ үнэд шингээнал дагдлаан өхөх гэж эрмэлзэх нь эцсийн дүндээ хэрэглэгчбү юу иргэн Танд, надад, бидэнд үүрүүлсэн авлигын төлөө болно.⁵ Дээрх жишээг

⁴<http://www.iaac.mn/index.php?coid=1349&cid=144>

⁵ Авлигатай тэмцэх газрын дарга Б. ДАНГААСҮРЭН

харахад шуудайн доторх ялзарсан нэг төмс бусад төмсийг ялзрахад хүргэдэг шиг нэг л хүний шунахай үйлдэл нийгмийн ялзалд нөлөөлж байдгийг харж болно.

Гадаадын зарим улсад:

Сингапурулсньолонулсынавлигыниндексээрээ эхний аравт багтдаг байна. Сингапурт авлигын эсрэг тэмцэл амжилтанд хүрэхэд олон хүчин зүйл нөлөөлсөн гэдэгтээ хэн ч маргахгүй. Гэхдээ авлигын эсрэг хатуу зогсож, тэмцэж чаддаг Сингапурын улс төрчдийн хүсэл зориг хамгийн чухал хүчин зүйл болсон ба авлигын хор хөнөөлийг нийтээрээ ухамсарлаж, нийгмийн бүх түвшинд авлигыг үл тэвчих хандлагыг дэмжиж зоригтой, тууштай тэмцэж чадвал түүнийг устгах боломж байгааг Сингапурын туршлага бидэнд харуулж байна.⁶

Этиоп улсын холбооны ёс зүйн ба авлигын эсрэг хорооны⁷ авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, яллах гэсэн 3-н үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна. Авлигын эсрэг боловсрол, ёс зүйг хөхиүлэн дэмжих замаар авлигыг үл тэвчих үзэл баримтлал бүхий олон нийтийн ухамсрыг төлөвшүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах нь Зүндсэн зорилтуудын нэг болдог байна. Авлигын эсрэг ёс зүй болон боловсролыг дээшлүүлэх нь авлигатай тэмцэх ажлын гол хэсэг гэж үзэж үйл ажиллагаагаа явуулж байна. Иргэдтэй нүүр тулсан ярилцлага хийж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургагч багшийн сургалтанд хамруулах зэрэг үйл ажиллагаа явуулснаар авлигатай тэмцэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгож, олон нийтийг шүгэл үлээгч, гэрч хамтрагч байдлаар комисстой хамтран ажиллахад дэмжлэг үзүүлсэн том алхам болсон байна. Олон нийт авлигатай тэмцэх ажиллагаа тэдний идэвхтэй оролцоогүйгээр амжилтанд хүрэхгүй гэдгийг ойлгож мэдрээд байна. Товчоор хэлэхэд хороо авлигатай тэмцэх үйл ажиллагааг олон нийтийн анхаарал болгож чадсан бөгөөд олон нийтийн санаа бодлын энэхүү өөрчлөлтийг хамгийн чухал ололт амжилт гэж үздэг байна.

⁶Ж.Батзандан.Авлигатай тэмцэх Сингапурын туршлага.,2009

⁷Шударга ёс сэтгүүл-6р дугаар

Дүгнэлт, санал:

“Австриулсадтөрсөн, ГермандболгадаадыниргэнболохГитлер улстөрийнүйлажиллагааньямар ч туршлагагүй, хөрөнгөмөнгөгүй, дээдсийнхүрээлэндямар ч хэлхээхолбоогүйбайсанмөртөө 14-хөн жилийндотордэлхийнтомоохонгүрнийудирдагчболжчадсанньхачирхалтай. Хосгүйуранилтгэгчбайсныхувьдолонтүмнийгшийдвэрлэхүйлажиллагаандчиглүүлэн зоригжуулжчадаажбайжээ”.**МайклХ.Харт**

Үгээрээ бүх л бүтэн үндэстнийг хөдөлгөж байсан олон олон удирдагчдийн жишээг түүхийн хуудаснаас харж болно. Би авлигыг оюун санаанаас ундрэн гардаг муу бодлуудын үр дүн гэж боддог. Цалин бага, хүмүүс авлига авахад хүргэдэг зэрэг авлигачдын тайлбар бол зүгээр л шалтаг. Шунахай хувиа бодсон, шударга бус сэтгэлгээний үр дагавар.

Тиймээс авлигыг зогсоохын тулд ашиг сонирхлын зөрчилдөөнийг арилгах, хөрөнгийн мэдүүлэг гаргуулах, мөрдөн шалгах, төсвийн хөрөнгийг нээлттэй байлгах зэрэг олон ажлуудыг хийхийн зэрэгцээ нийгмийн сэтгэхүйг өөрчлөх тэр дундаа Монгол Улсын маань ирээдүй болсон хүүхэд залуучуудын сэтгэлгээнд хувьсгал хийх цаг болжээ. Нийгэмд дэх боловсон хүчин болох оюутнууд бид оюутны ширээнээсээ босохтой авлигыг үл тэвчих үзэлтэн болно гэдэг бол нийгэмдээ оруулж буй том хувь нэмэр юм. Тиймээс дараах зүйлийг санал болгож байна.

- Оюутнуудад авлигын сөрөг үр дагаврын тухай сургалт зохион байгуулах
- Оюутнуудыг сургагч багшаар бэлтгэн, ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад насны онцлогт нь тохирсон шударга ёсыг төлөвшүүлэх зорилго бүхий сургалтын хөтөлбөр зохион хэрэгжүүлэх

Авраам Линкольны хэлсэн “Төр, түшмэл нь хариуцлагатай, иргэд нь шударга байж авлигыг хязгаарлана” гэсэн үгээр илтгэлээ дуусгая.